



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

186 /186/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.23

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ДЭД САЙД Б.БАЯРМАГНАЙ БХЭШХ-Д АЖИЛЛАЛАА



Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухаан үүсэж хөгжсөний 100 жилийн ойн өдрийг тохиолдуулан Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан

ажлын хэсэг Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэнд ажиллалаа. Энэ хүрээнд тус хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал,

Цэргийн урлаг судлал, Байлдааны зэвсэглэл, техник, технологи судлал, инновац, Батлан хамгаалахын дүн шинжилгээ, Цэргийн түүх судлалын төвүүдийн

үйл ажиллагаа болон шинээр зохион бүтээгдсэн шинжлэх ухаан, инновацын бүтээлүүдтэй танилцаж тодорхой үүрэг чиглэлийг өглөө.

Мөн үеэр тус хүрээлэнгийн захирал, хурандаа Б.Эрдэнэбат "Манай байгууллага өнгөрсөн оноос эхлэн илүү өргөн цар хүрээнд ажиллах зорилгыг дэвшүүлж байгаа. Засгийн газар, БХЯ, ЗХЖШ-аас техник, технологийн чиглэлээр тусгаж байгаа баримт бичгүүдэд голдуу тунхаглалын шинж чанартай заалтууд орсон байдаг. Өнөөдөр Батлан хамгаалахын сайд "Хандлагаа өөрчилье, хариуцлага нэмэгдүүлье" гэх уриалгыг дэвшүүлэн ажиллаж байгаа. "Хандлагаа өөрчилье" гэдэг нь тунхаглалын чанартай тогтолцоонд оруулья гэсэн үг юм. Манай хүрээлэн ч мөн адил яг л энэ чиглэлд ажиллаж байна. Богино хугацаанд маш үр дүнтэй ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлж чадлаа. Энэ долоо хоногт шинжлэх ухааны ажилтны өдөр тохиож байна. Үүнийг угтаад Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Техник, технологийн шинэ бүтээлийн уралдаан зохион байгуулагдсан. Уралдаанд оролцож байгаа бүтээлүүд урьд жилүүдийг бодоход чанар, бүтээмж, цаашид цэргийн зэвсэглэлд нийлүүлэгдэх боломжийн хувьд илүү сайжирсан нь харагдаж байна" гэв.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ ВЛАДИМИР МИХАЙЛОВИЧ КУЛИКОВ МОНГОЛ УЛСАД АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙЖ БАЙНА

ОХУ-ын Дорнод цэргийн тойргийн Агаарын довтолгооноос хамгаалахын болон агаарын цэргийн хүчний 11 дүгээр армийн командлагчийн орлогч, хошууч генерал Владимир Михайлович Куликов болон албаны бусад хүмүүс Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байна. Айлчлалын үеэр Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын удирдлагуудтай уулзалт хийлээ.

Уулзалтад Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч,

хошууч генерал О.Энхбаяр, АЦК-ын УТХ-ийн дарга, хурандаа Б.Энхзоргол, УНХ-ийн дарга, хурандаа Н.Очирбат, АДХХ-ийн дарга, хурандаа Э.Батсайхан болон ОХУ-ын Дорнод цэргийн тойргийн Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Тараев Иван Степанович, ОХУ-ын Дорнод цэргийн тойргийн Агаарын довтолгооноос хамгаалахын болон Агаарын цэргийн хүчний 11 дүгээр армийн командлагчийн цэрэг-улс төрийн орлогч, хурандаа



Сурсыков Сергей Викторович, ОХУ-ын Дорнод цэргийн тойргийн 266 дугаар дайрагч нисэхийн тусгай хорооны захирагч, хурандаа Малинин Денис Сергеевич болон албаны бусад хүмүүс оролцлоо. Тус уулзалтаар хоёр орны агаарын цэргийн өнөөгийн болон цаашдын хамтын ажиллагааны талаар санал

солилцсон юм. Уулзалтын дараа айлчлалын бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний 337 дугаар ангид ажиллаж нисэх зурвасын ашиглалтын байдал, аэродромыг тоноглох ажлын явцтай танилцав. Мөн өдөр бүрэлдэхүүнийг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг хүлээн авч уулзах юм.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
369,688 +287

ЭДГЭРСЭН
536,920

НАС БАРСАН
1,875 +8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6441 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ
119

ЭДГЭРСЭН
6198

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 258,369,075

Эдгэрсэн
Нийт: 233,828,320

Нас барсан
Нийт: 5,174,182

Түүхэнд энэ өдөр

1949 он.

БНМАУ ба ЗХУ-ын

Засгийн газрын хооронд

"ЗХУ-ын цэргийн

сургуулиудад МАХЦ-ийн

албан хаагчдыг сургах ба

хангах зардлуудыг нөхөн

төлөх журмын тухай"

гэрээ байгуулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-5	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,275.0	3,285.0
CNY	445.80	449.80
RUB	38.50	40.00
JPY	24.65	25.23
KRW	2.38	2.46

ЗУРХАЙ

2021.11.23 МЯГМАР ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЫН 19/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Сайн нөхөртэй нөхөрлөнө

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.10-17.07

БАРИЛДЛАГА:

Хүчин төгсөх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Хурьцахуй

Суудал:

Хий

Энэ өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, сүм дуганыг сэргээх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, гөлөг тэжээх, уул овоо тахирад муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал "Сайн нөхөртэй учирах" хэмээхсэн байна.

Цахим шууданд

ДЭД ПРОФЕССОР М.БЯМБАРАГЧААД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухаан үүсэж хөгжсөний 100 жилийн ой энэ долоо хоногт тохиож байна. Энэхүү түүхэн өдрийг тохиолдуулан Монгол цэргийн музейн нэгэн үеийн төлөөлөл дэд профессор, чөлөөнд байгаа дэд хурандаа М.Бямбарагчаад тус байгууллагын хамт олон өчигдөр хүндэтгэл үзүүлээ. Дэд профессор М.Бямбарагчаа нь 1951

онд Завхан аймгийн Завханмандал сумын нутаг Багахайрхан хэмээх газар төрсөн. Тэрээр 1969-1973 онд Цэргийн ерөнхий дээд сургуулийн холбооны ангид онц дүнтэй суралцахдаа Д.Сүхбаатарын нэрэмжит цалин авч байсан нь түүний хичээл зүтгэлийг илтгэн харуулсан үйл явдал болж байжээ. Улмаар 1982 онд ЗХУ-ын Москва хотын В.Н.Лениний нэрэмжит

Цэргийн улс төрийн академи, 1989 онд мөн академийн дээд курсийг дүүргэсэн байна. Тэрээр Монгол Улсын Зэвсэгт хүчинд нийт 43 жил ажиллахдаа цэрэг, армийн шинэчлэлд идэвх зүтгэлтэйгээр оролцож, нийгмийн хөгжлийн шинэ үед зохион байгуулах сургалт, соёл хүмүүжлийн ажлыг төлөвшүүлэхэд үр бүтээлтэй ажилласан гавьяат үйлсийн эзэн юм.

БЭЛЭН БАЙДЛАА ШАЛГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын ЦССХХ-ийн дарга, хурандаа Т.Тогмиддүүмийгээр ахлуулсан комиссын бүрэлдэхүүн Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудад хяналт шалгалт явуулах ажлын хүрээнд бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшин, цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг шалгаж байна. Мөн 2021 оны цэргийн албанд шинээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдын анхан шатны бэлтгэл сургалтын явц, чанар байдал, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгаж, үүрэг даалгавраар хангаж байгаа юм. Энэ дагуу комиссын бүрэлдэхүүн энэ сарын 18-ны өдөр Зэвсэгт хүчний 326, 120 дугаар ангиудад ажиллаж, шалгалтын удирдамжийн дагуу Зэвсэгт



хүчний Хуурай замын цэргийн командлагчийн бэлэн байдлыг хангах удирдамжийн хэрэгжилт болон тус ангиудын хуулиар хүлээсэн бусад үүрэг гүйцэтгэх бүлгүүдэд "Цугларалт" дохио өгч, бие бүрэлдэхүүний хувийн бэлтгэл, зэвсэг, хамгаалах

хэрэгсэл, үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай багаж, ар талын табель хэрэгслийг жагсаалын талбайд үзлэгт тавиулж, томилгоот авто техникүүдийг хөдөлгөөн үйлдүүлж, бэлэн байдлыг шалгалаа. Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР

ГЭРЭЛ ЗУРАГ НЭГ АГШИН

2021 оны хоёр дугаар ээлжээр татагдан ирсэн байлдагчид ар гэрээс нь ирсэн анхны захидлуудаа уншиж буй нь. Зэвсэгт хүчний 256-р анги 2021 оны 2 дугаар ээлжээр татагдан ирсэн байлдагч Э.Мөнхбатад



БИЕЙН ТАМИРЫН 17 НЭР ТӨРЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БҮХИЙ БЯЛДАРЖУУЛАХ ТАНХИМТАЙ БОЛОВ



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу офицер, даргалах албан тушаалын ахлагч нартай "Цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж явуулах онцлог" сэдвээр "Хандлагаа өөрчилье, хариуцлагаа нэмэгдүүлье" уриатай хоёр өдрийн сургалтыг зохион

байгууллаа. Сургалтын үеэр боловсролын удирдлагын магистр М.Адилбиш "Байгууллагын соёл, эерэг хандлага" сэдвээр, уулын спортын ОУ-ын хэмжээний мастер Эверестийн оргилд анх гарсан уулчин, бэлтгэл дэд хурандаа Н.Жуков нар урилгаар хүрэлцэн ирж байгууллагын соёл, эерэг уур амьсгал, хандлага хариуцлагын талаар сонирхолтой лекц уншив. Тус сургалт нь уулчин хүний

тэсвэр тэвчээр, эр зоригийг харуулсан үр дүнтэй сургалт болж өнгөрсөн юм. Мөн ангийн бие бүрэлдэхүүний ажиллах, сурах, бие бялдрыг хөгжүүлэх орчныг сайжруулах ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн буцалтгүй тусламжаар биеийн тамирын 17 нэр төрлийн тоног төхөөрөмжийг анги хүлээн авч бялдаржуулах танхимыг тохижууллаа.



ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА ХААГЧИД БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ...



Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.5, 3.2.7 дугаар заалтуудын дагуу Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны А/409, А/540 дүгээр захирамжаар 2020-2022, 2021-2023 онуудад цэргийн дүйцүүлэх албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа 70 гаруй алба хаагч тус

аймгийн Хархорин суманд шинээр байгуулагдсан орон нутгийн өмчит "ӨВ АГРО" ХХК-ны Гурил тэжээлийн үйлдвэрийн малын ногоон тэжээл тариалах, хураах талбайд 9 дүгээр сарын 29-ний өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд амжилттай ажиллаж байна. Дээрх хугацаанд цэргийн дүйцүүлэх алба хаагчид 5 ээлж /1 ээлж 10-15 хүнтэй 14 хоног/-ээр томилогдон үүрэг гүйцэтгэж, 410 га талбайгаас 45000 гаруй боодол ногоон

тэжээлийг хурааж, сумдын аюулгүйн нөөцөд тээвэрлэх тээврийн машинд ачих зэрэг ажлуудыг шуурхай, чанартай хийж, аймгийн аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд идэвх, санаачилгатай оролцож байна. Аймгийн удирдлагаас 14 хоног тутам дүйцүүлэх алба хаагчдын ажлын нөхцөл байдалтай танилцаж, тэдэнд баярлаж, талархсанаа илэрхийлэн, үүрэг гүйцэтгэх орчин нөхцөл, ахуй хангалтад байнга дэмжлэг үзүүлж байна. Дэд хурандаа Ч.АДЪЯА